



ТҮГЭЭМЭЛ ОЮУН  
СУРГУУЛИЙН 2023-  
2024 ОНЫ  
ХИЧЭЭЛИЙН  
ЖИЛИЙН  
СУРГАЛТ,  
ХҮМҮҮЖЛИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ  
ТАЙЛАН

# **1. Хүүхэд бүрийн танин мэдэхүйн хөгжилд дэмжлэг үзүүлэх, тэдний ялгаатай байдлыг тооцон, суралцахуйн хоцрогдлыг арилгах чиглэлээр хийсэн ажил, түүний үр дүн**

**Хэрэгжилт:** Сурагчдын ялгаатай байдал, сурлагын хоцрогдлыг бууруулахад хамтран ажиллах зорилгоор ангийн багш болон тухайн ангид хичээл ордог багшийн хамт багш нарыг багт нэгтгэх менежментийг туршин сурагчдын сурлагын бодит байдал, шалгалтын дүнгийн талаар ярилцаж, хичээл ордог багш нар өөр хоорондоо санал солилцож, хоцрогдлын бууруулах сайжруулахын тулд ямар дасгал даалгавар, хүүхэд хөгжлийн ажил зохион байгуулсан зэрэг үр дүнгээ хэлэлцэж дараагийн 7 хоногт сурагчидтай хэрхэн ажиллах чиглэлээ гарган ажиллаж байна. Бага ангид 1-5 дугаар ангийн анги удирдсан багш болон хичээл ордог нийт 7 багш сурагчдын суралцахуйн хоцрогдлыг бууруулахад багийн ажлын төлөвлөлт гарган ажиллаж байна. Үүнд:

- Сурагчдын бие даах үйлийг дэмжих, сургалтын хоцрогдлыг арилгах чиглэлээр
- минутын уншлага, монгол хэл, математикийн дасгал даалгаврыг тогтмол ажиллуулж байна.
- 
- Сурагчдын зөв хурдан унших чадварыг ахиулах зорилгоор 3-5 дугаар ангийн сурагчид хичээлийн эхний 10 минутад уншлагын цаг зохион байгуулж, ахицыг тооцон ажиллаж байна.
- Бага боловсролын сурагчдын үзсэн агуулга бататгах зорилгоор 5 хоног
- бүрээр гэрийн даалгавар боловсруулан ажиллаж байна.

## Үр дүн:

- Сургуулийн бүх сурагчид Соробан сампин- Ой тогтоолтын сургалтаар 7 хоногт 3 удаа хичээлэлсэнээр унших хурд, ойлгон унших, ой тогтоолт, цээж бодолтын хурд хөгжиж сурагчдын ялгаатай байдлыг тодорхой хэмжээнд нөлөөлж ахиц гарч байна.

**2. Хичээлээс гадуурх сургалтыг ажлыг дэмжин, хүүхдийн оролцоо хэрэгцээнд суурилсан секц, дугуйлангаар сурагчдыг хөгжүүлсэн ажлын үр дүн**

**Хэрэгжилт:** Хичээлээс гадуурх дугуйлан, секцүүд Соробан сампин Ой тогтоолт, Туялзуур сэлэмний олон улсын эрхтэй сургалтуудад 1-5 ангийн нийт 67 сурагч хамрагдаж байна. Хичээлийн жилд 2 удаа сурсан мэдсэн зүйлээ эцэг эх асран хамгаалагч нартаа тайлаж хэвшсэн. Энэ хичээлийн жилд Соробан сампин-Ой тогтоолтын аймгийн аварга шалгаруулах Дорнод Тоуа сур тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.

● **Үр дүн:** Дээрх хичээлээс гадуурх үйл ажиллагаад хамрагдсанаар сурагчдын сэтгэн бодох чадвар, ой тогтоолт, өөртөө итгэл нэмэгддэг. Энэ хичээлийн жилд

● Үндэсний аварга шалгаруулах тэмцээнд

1-р ангийн сурагч Г. Есөн-Эрдэнэ, Т. Энэрэл, Ж.Эрхэт, 4-р ангийн сурагч М.Үлэмжбадрах, Б.Төгсжаргал нар амжилт үзүүлж, олон улсын тэмцээнд оролцох 5 эрх аваад байна. Мөн орон нутгаас хэрэгжүүлж буй хүн болох багаасаа хөтөлбөрт хамрагдан 30 хүүхдийг хамруулан Дорнод аймгийн хүүхэд багачуудад Соробан Ой тогтоолтын сургалтыг заасан нь давуу талтай байлаа.

### **3. Багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд хийсэн анализ, түүний мөрөөр хийж буй ажил**

**Хэрэгжилт:** Багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд энэ хичээлийн жилд анх удаа оролцсон.

### **4. “Зэрэгтэй багшийн манлайлал” үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн**

**Хэрэгжилт:** Бага ангийн багш Д.Энхжаргал, Д.Ариунцэцэг нар декрэтний амралтаа авсан тул Ж.Долгормаа, Б.Болортуяа багшийг гэрээгээр ажиллуулж, соробан сампин ой тогтоолтын багш нартай хурдан уншуулах ой тогтоолтын хичээлээр туршлага солилцсон. Мөн Баруун тархи хөгжүүлэх сургалтын багш Б. Соёлмаа Үндэсний аварга шалгаруулах тэмцээнд сурагчдыг бэлдэж, 8 сурагч алт мөнгөн цом хүртэж ажлын амжилтаа ахиулсан.

## **5. Бага боловсролын багш нарын ёс зүйн хэм хэмжээ, хамт олноороо харилцааны эерэг хандлага, соёл төлөвшүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн**

**Хэрэгжилт:** Багш ажилчдад хүүхэд хамгааллын бодлогыг танилцуулан хүүхэд хамгааллын ёс зүйн батламжид гарын үсэг зуран баталгаажуулж, хүүхдийн эсрэг ёс зүйн алдаа дутагдал гаргахаас урьдчилан сэргийлж сургуулийн удирдлагын зүгээс яриа танилга тогтмол хийж байна. Мөн Би-ээс бид сэдвээр хувь хүний үнэт зүйл, хөгжил, багаар ажиллах чадварыг хөгжүүлэх 2 удаагийн сургалт, Боловсролын хуулийн талаар 1 удаагийн сургалтыг тус тус явуулсан болно.

Өглөө бүр сургуулийн захирал болон жижүүр багш нар угтах үйлчилгээг тогтмол хийж хэвшсэн.



**Үр дүн:** Багш сурагчид бие биенээ хүндэтгэх соёлд суралцаж байна.



## **6. Эцэг эхийг сургалтын үйл ажиллагаанд татан оролцуулах чиглэлээр хийгдсэн ажлууд, үр дүн**

**Хэрэгжилт:** Эцэг эх, асран хамгаалагч харгалзан дэмжигчдын хурлаар дамжуулан хүүхдийнхээ хичээлд туслахад нь дэмжлэг болгож үзүүлэх хичээл 2 удаа хийсэн. Мөн ээжүүдийн уулзалтыг тус тус зохион байгуулсан болно

Сурагчдын сурах таатай орчинг бүрдүүлэх зорилгоор хүүхэд хөгжлийн танхимтай болж, TV, спикер, микрофон, mini soccer, оньсон тоглоомнууд, байршуулан амралт чөлөөт цагийг өнгөрүүлэх таатай орчныг бүрдүүлээд байна.

**Үр дүн:** Хүүхдүүд сурч хөгжих таатай орчноор хангагдсан.

## **7. ЭДҮТЭН цахим системийн хэрэгжилт, үр дүн, ирэх жилийн бэлтгэл ажлын талаар**

**Хэрэгжилт:** ЭДҮТЭН цахим системийг хэрэгжүүлээгүй болно.

## **8. Бага ангийн сурагчдын цүнхний жин бууруулах чиглэлээр хийсэн ажил**

**Хэрэгжилт:** Сургуулийн хэмжээнд суралцагчдын цүнхний жинг бууруулах нуруунд ирэх ачааллыг багасгах үүднээс 1-5 дугаар ангийн нийт суралцагчид 1 дэхээс 4 дэх өдрийг хүртэл цүнхгүй өдөр болгож өдөр өнжүүлэхийн цаг дээрээ гэрийн даалгавараа хийж, цүнхээ ангидаа орхиж явдаг бөгөөд баасан гарагт цүнхээ авч явдаг болно.

Эцэг эх, асран хамгаалагч харгалзан дэмжигч нарт дараах зөвлөмжийг өгч ажиллаж байна.

Үүнд:

- хичээлийн хуваарийн дагуу цүнхэнд хичээлийн номыг хийж явуулах
- Цүнхний нийт жин биеийн жингийн 10%-иас хэтрэхгүй байхад анхаарах
- Цүнхэндээ хуваарийн дагуу хичээлээ ялгах, цэгцтэй байх, илүү зүйл хийж авч явахгүй байх талаар зөвлөгөө өгөх

## **Үр дүн:**

- Даваагаас пүрэв гаргат өдөр өнжүүлэхийн цаг дээрээ гэрийн даалгавараа хийгээд ангидаа цүнхээ орхиж явах хэвшилтэй болсон.
- 1-2 дугаар ангийн сурагчдын 90% цүнхний ачаалал биеийн жинд тохирсон байсан.
- Сурагчид өөрсдөө цүнхний жин ямар байх ёстойг тооцоолон гаргаж сурсан.
- Сурагчид цүнхний ачаалал хэтэрсэн үед биед сөрөг нөлөөтэй болохыг ойлгож, түүнээс сэргийлэх арга замаа олсон.

**9. Байгалийн ухаан, технологи, инженер, математикийн /STEM/ сургалт, хэрэглэгдэхүүний ашиглалт, үр дүн**  
**Хэрэгжилт: STEM сургалт хэрэгжүүлээгүй болно.**

Баярлалаа та бүхэндээ